Технологийн зориулалтар хэрэглэх цэвэр усны хэмжээг багасгах хаягдал усны хэмжээг бууруулах зорилгоор хаягдлын усыг эргүүлж ашигладаг. Баяжуулах хэсэгт алт агуулсан элсийг угаахдаа уурхайн ухашын шүүрлийн усыг ашиглах ба нийт хэрэгцээний 70%-г нь эргэлтийн усан сангаас хангагдах учир баяжуулах хэсгийн ойролцоо 375м³ багтаамжтай усан санг байгуулна. Энэхүү усан сан нь 3 хэсгээс бүрдэнэ. Эхний болон хоёр дахь усан сан нь баяжуулах хэсгээс ирж буй булингатай уснаас хатуу буюу хүнд хольцуудыг тунгаан авч үлдэх буюу цэвэр усыг шүүрүүлэх зориулалттай. Дараагийн усан сан нь

баяжуулах хэсэг рүү буцаан шахах цэвэр усыг хуримтлуулах үүрэгтэй юм.


Хүснэгт 12. Хаягдлын сангийн үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Бохирын нуурын	Эргэлтийн усан сан
	Хаягдлын далангийн талбай	м ²	750	500
	Далангийн урт	метр	80	70
	Далангийн өргөн	метр	1	1
	Далангийн ажлын налуу	хэм	45	45
	Далангийн эсрэг налуу	хэм	45	45
	Далангийн өндөр	метр	0.5	0.75
	Хаягдлын цөөрмийн	м³	375	375
	эзэлхүүн			

4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

4.1. Уурхайн хотхон

“Одод Гоулд” ХХК нь ажилчдын гэр орон сууцыг ажиллагсадын амьдрах түр орон сууцны зориулалтаар ашигладаг. Мөн хоолны газар, халуун ус, оффисын зориулалтын зөөврийн барилга, агуулахын контейнер, бие засах газар, биеийн тамирын талбай, засварын талбай, зогсоолын талбай г.м байгууламжуудыг байгуулсан. Уурхайн ажиллах хугацаа бага тул суурин байгууламж байгуулахгүй.



Зураг 7. Уурхайн хотхоны бүдүүвч зураг

ШТМ-ын агуулах

Шатахуун хадгалахад зориулж 8м³ ёмкость 1ш, бусад ШТМ-ыг зориулалтын савтай нь

хадгална. ШТМ борлуулдаг компанитай байгуулсан гэрээний дагуу тогтсон хуваарийн дагуу уурхайд ШТМ-ыг хүргүүлнэ.

4.2. Холбооны байгууламж

Уурхайн тосгонд харилцаа холбооны хувьд МЦХ-ны үүрэн холбооны сүлжээтэй. Уурхайн оффис нь өндөр хурдны интернэтэд холбогдоно. Уурхайн тосгонд сансрын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авч байна.

4.3. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны хэрэглэгч нь усны насос, угаах төхөөрөмж, гагнуурын аппарат болон гал тогоо, гэрэлтүүлэг г.м бусад жижиг хэрэглэгчид байна. Уурхайн ажиллах хугацаа богино, цахилгаан эх үүсвэр байхгүй уурхайн цахилгааны хэрэгцээг дизель станцаар хангаж байна.

Баяжуулах хэсэг нь тосгоноос 0.6-1.6 км зайд байрлана. Баяжуулах хэсгийн цахилгаан хангамжийг 70 кВт-н КС70 дизель станцаар хангана. Уурхайн тосгон болон засварын хэсгийн цахилгаан хангамжийг 20 кВт-ын КС20 дизель генератороор хангана.

4.4. Усан хангамж

Ил уурхайн ус таталт

Ашиглалт явуулах талбайн хувьд дөрөвдөгчийн бэл, хормойн гаралтай сэвсгэр хурдас дахь жигд бус тархалттай газрын доорх ус оршино. Өлзийт голын ус агуулагч хурдас нь элс, хайрга, хайрганцар найрлагатай байх ба татмын хэсэгтээ 1.8-2.0 м гүнд жигд түвшингээр уст давхара илэрнэ.

Энэ хэсэгт усны ундарга нь 4.0 л/сек байдаг нь сүүлийн 20 жилийн ажиглалтаар тогтоогдсон бөгөөд усны хатуулаг нь 2.7 мг.экв/л юм. Уурхайн шүүрлийн усыг баяжуулах төхөөрөмжийн хэрэглээнд хэрэглэнэ.

4.5. Технологийн усны хэрэгцээний тооцоо

Баяжуулах үйлдвэрийг хоногт дундажаар 800 м³ элсийг угаана гэж үзвэл хоногт 2128м³ ус зарцуулна. Баяжуулах төхөөрөмжийн хаягдал усны бүрэлдэхүүнд хаягдал булинга, шүүлтүүрийн шүүгдэс болон үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээний бохир ус зэрэг багтана. Технологийн зориулалтаар хэрэглэгдэх цэвэр усны хэмжээг багасгах, хаягдах усны хэмжээг бууруулах зорилгоор түүнийг эргүүлэн ашиглахаар тооцов.

Уурхайд шүүрэн орж байгаа ус нь баяжуулалтын бохир усан дахь бохирын агууламжийг бууруулахад нэмэр болохоос гадна баяжуулалтын усан хангамжийн гол эх үүсвэр болно. Уулархаг, гол горхитой хэсэгт усыг их хэмжээгээр хуримтлуулан олон дахин эргүүлэн ашиглах нь ус хэмнэж байгаа мэт харагдах боловч эцсийн дүнд агуулах нуур цөөрмийн асуудлаас болж голд нийлүүлэхээс өөр аргагүйд хүрдэг. Энэ үед ус нь маш нарийн ширхэг бүхий олон дахин угаагдсан тундас хэлбэрийн зуурмаг болон хувирсан байдаг. Энэхүү зуурмаг нь голруу орсоноор голын ёроолыг бүрхэн, урсгалд цохиулж дэгдсээр олон өдөр сараар голыг бохир урсахад хүргэдэг. Иймд усыг аль болох ойр ойрхон

юүлж байна.

Хүснэгт 13. Технологийн усны хэрэгцээ

он	Элсний хэмжээ, м ³	Усны норм, м ³ /м ³	Усны хэрэлээ, м ³	Эх үүсвэр			Усны төлбөр, төг	
				Эргэлт	Шүүрлээр	Голоос	Нэгжийн үнэ, төг	Нийт үнэ, сая төг
2025	72530.0	2.66	192929.9	135050.9	192929.9	-	1674.2	-

4.6. Уурхайн усан хангамж

Баяжуулах үйлдвэрийн хэрэглээний усыг шүүрлийн болон гадаргын усаар хангахаар төлөвлөсөн бөгөөд уурхайн шүүрлийн усны нөөц нь 15626.6 м³/хоног байгаа тул Өлзийт голоос шаардлагатай үед усыг татаж хэрэглэнэ. Ашиглалтын эхний жил баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн 93.5%-г шүүрлийн усаар, 6.5%-г гадаргын усаар хангана. 2 дахь жил 30% -ийг цэвэр усаар 70% -ийг эргэлтийн усаар хангана.

Баяжуулах үйлдвэрийн усан хангамжид БНХАУ-д үйлдвэрлэсэн 150м³/цаг хүчин чадалтай 4РМА маркын насос 2ш Өлзийт голоос ус татах болон баяжуулах төхөөрөмж тэжээхэд ашиглахаар төлөвлөлөө.

Унд ахуйн усыг уурхайн тосгонд гаргасан 0.2л/с ундаргатай худгаас хангана.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЗОРИЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгийн тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг мөн..

БОМТ -ний бүрдэл хэсэг, агуулга

БОНХАЖЯ-ний Сайдын тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд дараах зүйлийг оруулахаар тусгасан байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын (явцын) төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө,

байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схем, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, уул уурхайн төслийн хувьд хаалтын зорилт, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө орно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээнд нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, тухайн орчноос дээж, сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, шинжилгээ хийх давтамж, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Хүснэгт 14. БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга

	БОМТ-ний бүрдэл хэсэг	Агуулга
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ БОМТ-г хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоог ажиллуулах, бэхжүүлэх, хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах Байгалийн баялаг, нөөц ашигласны төлбөр, хураамж Сургалт, мэдээллийн үйл ажиллагаа Газар, байгалийн нөөц ашиглалт, хэмнэлт, хамгаалалт, хяналт-шинжилгээ, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам
	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах, ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, үржүүлэх, нутагшуулах, тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх; Байгаль орчны нөхөн сэргээлтийн стандарт, заавар, журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Биологийн олон янз байдлыг хамгаалах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, үр дүнг тайлагнах хэлбэр, хяналт тавих механизм
	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрхийн бүртгэл, судалгаа Нөхөн олговрын арга хэмжээ, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын зардал
	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төсөл хэрэгжих бүс нутагт хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх соёлын өв дурсгалыг хамгаалах
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Байгалийн гамшиг түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоогдсон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шаардагдах зардал
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Хог хаягдлын тухай хууль, стандартыг хэрэгжүүлэх хатуу, шингэн, хийн хаягдлыг багасгах, зайлуулах, устгах арга хэмжээ

	ТЖБОМТ-г хэрэгжүүлэх Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм, байгаль орчны бодлого, удирдлагын зохион байгуулалт
	ТЖБОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийт, нутгийн ард иргэдэд мэдээлэх, тайлагнах Төслийн үйл ажиллагаатай холбоотой гарсан санал, шүүмжлэлийн хариу арга хэмжээ, гомдол барагдуулах үйл ажиллагаа
0	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт; Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд; Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд; Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн; Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

5.1. БОМТ хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь 180 14001 2004 (МК8 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (180 14001, 2004).

БОУТ-ний бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

- Байгаль орчны бодлого:** Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.
- төлөвлөлт:** Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;
- Хэрэгжүүлэлт:** Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц, үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;
- Хяналт, сайжруулалт:** Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;
- Удирдлагын хяналт:** Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянах

5.2. БОМТ-ний хэрэгжилтийн хяналт

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ-ний хэрэгжилтийн хяналт дараах байдлаар хийгдэнэ:

1. БО-ний нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална (заалт 9.8).
2. Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнах ёстой (заалт 9.9).
3. БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, БО-ний хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны ТББ хяналт тавина (заалт 9.12).
Шаардлагатай тохиолдолд БО-ний нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шийдвэрээр БОМТ-ний хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт хийж, дүгнэлт гаргах бөгөөд уг ажилд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна (заалт 9.13).
4. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага БОМТ-ний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг тусгай журмын дагуу шийдвэрлэнэ (заалт 9.14).
5. Байгаль орчны аудитийг 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагаар Хийлгэх

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Цар хүрээ	Нэгжийн өртөг /мян. төг/	2025 онд зарцуулах нийт зардал /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар			400.0			
Үйлдвэрээс ажилчдын амрах байр хүртэлх түрж тэгшилсэн шороон замаар зорчих үед хурд хэтрүүлэн явснаар тоосжилт үүснэ.	Хурдны заалтын тэмдэг тавих	Шороон зам	1 тэмдэг, тэмдэглэгээ 100.0мян.төг *4ш=400.0	400	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага МЖ 4597:2013
Дотоод замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд 2 л/м² нормоор услаж байх, зам талбай босох гадаргууг хөрс барьцалдуулагч бүхий усаар шүрших	Замын усалгааг хуурайшилттай үед хийх		Дотоод үйл ажиллагааны зардлаар	Хуурайшилттай үед (Тоос шороо ихээр боссон үед)	Байгаль орчны Сайдын 2015 оны А301 дүгээр тушаал	
Гадаргын болон газрын доорх ус			1,350.0			
Өлзий голын усны урсацыг хамгаалах, сэргээх	Гадаргын болон газрын доорх усыг хамгаалах талаар ордын нөхцөлд тохирсон цогц бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах	Өлзий гол	1,000.00	1,000.00	2025	Усны тухай хууль
	Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд ус хамгаалах тухай тусгаж өгөх	Уурхайн ажилчид	-		2025	Усны бохирдлын төлбөрийн журам
	Зуны улиралд аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автаж болзошгүй тул үерийн уснаас	Уурхай	350	350	2025	Байгалийн нөөц ашигласны
	хамгаалах, усыг хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ					төлбөрийн тухай хууль
	авах					
	Байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд	Уурхай	-	-		

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	яаралтай авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулах					
	Ахуйн хэрэглээнээс гарах бохир ус цэвэрлэх септик систем суурилуулах	Уурхай	ТЭЗҮ-д тусгасан уурхайн магадлаагүй ажлын зардалаас авах	-	2025	
	Усны хомсдолоос сэргийлэх үүднээс Өлзийт голоос ус авч байгаа шугам хоолойн эхэн дээр тоолуур суурилуулах	Шугам хоолой	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025	
Дуу чимээ, доргио чичиргээ, дулаан			250.0			
Ажилчидын гар утас, компьютер, хэвлэх машин, \У\-П БгоайБапй- утасгүй интернэт зэргээс цахилгаан соронзон цацрагийн нөлөөлөл үүсгэнэ	Биоспин буюу цахилгаан соронзон долгион шүүгч авч ашиглах	Үйлдвэрийн талбайд	1 ширхэгийн үнэ 250.0 мян.төг* 1ш=250.0	250.0	2025 онд (1 удаа төхөөрөмж суурилуулах)	Үйлдвэрийн дотоод журмаар
	Сүү, тараг, нэрс, брокколи, соёолж г.м антиоксиадант агууламж ихтэй хоол хүнсийг ажиллагсдын хоолонд хэрэглэх	Нийт ажиллагсдад	Хоол, хүнсний хангамжийн зардал		Үйл ажиллагааны туршид	МЫ8 САС КСР 39-2011 МЫ8 4946:2005 стандарт
Газрын гадарга, хөрс			5645.0			
Газрын чанар доройтох, эвдрэх, бохирдох	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Уурхайн эзэмшлийн талбайд	5,645.0	5,645.0	2025 оны 2, 3-р улиралд багтаан	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам, Засгийн
						газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1дүгээр хавсралт
Уурхайн талбай хүртэл сайжруулсан шороон зам тавьснаас хөрс, ургамал гээд байх зүйлгүй болсон, ул хөрс эргэсэн сул шороо ихтэй унаган төрхөө алдсан	Уурхайн талбай болон шороон замын 2 талаар орон нутагт ургах боломжтой мод, бут тарих	Уурхайн талбай, зам дагуу	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд ногоон байгууламжийн тооцоог хийсэн.		2025 оны 2-р улиралд	МЫ86141:2011 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
Ургамал			-			

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Талбай доторх ургамлан нөмрөг устаж үгүй болох сөрөг нөлөөлөлтэй	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг орон нутгийн БОГ, газрын даамал нартай зөвшилцөн мод тарих газрыг сонгох	Орон нутагт	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах зардал тусгагдсан	Жил бүрийн III-р улиралд	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Мод тарих үндэсний өдөр
Байгалийн гамшиг, аваар осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх			-		
Уурхайн осол гэмтэл, тоног төхөөрөмжийн саатал зэрэгт ажиллагсад өртөх, хариу арга хэмжээ авч чадахгүйгээс үүдэн эрүүл мэндэд нь хохирол учрах	Уурхайн бүх ажилтануудыг ХАБЭА-н болон галын аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, өдөр бүр ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байх	Нийт ажиллагсад	Үйл ажиллагааны зардалд тусгах	өдөр тутам	Уурхайн дотоодын ХАБЭА-н зааварчилгааг мөрдөх
Байгалийн гамшгаас үүсэх нөлөөлөл	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх , эрсдэлийг бууруулах арга хэмжээг	Уурхайн барилга байгууламж	Үйл ажиллагааны зардалд тусгах		Гамшгийн тухай хууль 2017
	өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах				
Галын аюулаас урьдчилан сэргийлэх			-		
Гал түймрийн эрсдэл үүсэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрмийг үйл ажиллагааны турш мөрдөн ажиллах	Үйлдвэрийн хэмжээнд бүх ажилчид	Дотоод зохион байгуулалтаар	Үйл ажиллагааны турш	Галын аюулгүй байдлын дүрэм
	Галын дохиоллын системийг ашиглах	Үйлдвэрийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
Гамшгийн үеийн бэлэн байдлын талаар судлаагүй ажилчид гамшгийн нөлөөлөлд өртөх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг онцгой байдлын хэлтэстэй хамтран баталж, бүх ажиллагсадыг сургалтанд хамруулах.	Нийт ажиллагсад	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	
Ажиллагсадын эрүүл ахуйн талаар					
Уурхайн технологийн горим, үйл ажиллагаа нь ажиллагсадын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.	Ажиллагсдыг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх багц үзлэгт хамруулах	Нийт үйлдвэрийн ажиллагсад	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	ХАБЭА-н заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах				
Нийт			7,645.0		

5.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайн үйлдвэрийн талбай, зам, тосгон, овоолго, баяжуулах хэсэг зэрэг объектуудад үйл ажиллагаа явагдаж тодорхой хэмжээгээр эвдрэл үүснэ. MNS35915:2008 стандартын дагуу эвдэрсэн газрын ангиллыг дараах хүснэгтэд үзүүлэв. “Одод Гоулд” ХХК нь өөрийн тоног төхөөрөмжийг ашиглан нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх учир нөхөн сэргээлтийн ажилд нэмэлт хөрөнгө оруулалт шаардахгүй байхаар ТЭЗҮ-д тусгасан байна. Техникийн нөхөн сэргээлийг дотоод овоолгоор хийх тул зардлыг үйл ажиллагааны зардалд тусгав.

Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Ухашаа дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийнэ	Га	12	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Төлөвлөгөөт онд	
2	Биологийн нөхөн сэргээлт	Олон наст ургамлын үр цацна.	Га	3	1.875	5.6	Төлөвлөгөөт онд	

5.5. Биологийн олон янз байдлыг “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 17. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, Сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6	7
1	Гар аргаар ашигт малтмал олборлогч нарын хөндөж нөхөн сэргэлт хийлгүй үлдээсэн газар нөхөн сэргээлт хийх	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	ТЗ талбайд хамаарах хэсэгт			10000.0	Төлөвлөгөөт онд
	Нийт				10000.0		

5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд талбайд түүх, соёлын дурсгалт зүйл, газрын гадаргад ил харагдах археологийн олдвор байхгүй. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны явцад газрын хэвлийгээс археологи, палеонтологийн дурсгал илэрч болзошгүй тул нийт ажилчид, жолооч нарт анхааруулга сануулга өгч, хэрвээ түүх, археологийн дурсгалт зүйл илэрвэл ажлаа нэн даруй зогсоож сумын удирдлага, цагдаагийн байгууллагад мэдэгдэн, эрдэм шинжилгээний байгууллагад хандах нь зүйтэй.

Харин Археологийн хүрээлэнгийн судалгааны 2017 онд явуулсан судалгааны ажлын үр дүнд тус лицензийн талбайн хажуугийн талбайд 26 тооны дурсгалыг олж илрүүлэн баримтжуулсан байна. Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухайн хуулийн 6 дугаар бүлгийн 7.10, 17.12 заалтууд болон холбогдох журмын дагуу.

Хүснэгт 18. Түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологи	MV-006853, MV-006853 талбайн хэмжээнд археологи түүх соёлын өв илрээгүй						
2	Палеонтологи	Талбайн хэмжээнд тархсан хурдасаас эртний сээр нуруутай болон сээр нуруугүй амьтаны үлдэгдэл илрээгүй.						
	Нийт							

5.7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаанд химийн бодис хэрэглэхгүй.

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.8. Хог хаягдлын менежмент

Хүснэгт 19. Хог хаягдлын төрөл, хэмжээ, устгах хэлбэр

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог	Хог хаягдал ангилан ялгаж хаях	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	Удаа	400	5	2,000.00	2025 он	Хог хаягдлын тухай хууль; БОАЖ-ын сайдын А/433
хаягдлыг эх	зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих							тушаал “Ариун цэврийн тухай”
үүсвэр дээр нь ангилан, ялгах,								хууль;
хог хаягдлыг								БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын
дахин ашиглах								кодчилсон жагсаалт,
								тэдгээрийн зэрэглэл;
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх		Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2025-2029 он	БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал;		
	Энгийн хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад		Удаа			2025 он	БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх,	
	хүргүүлнэ.	цуглуулах, хадгалах, дахин боловсруулах;						
Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Хог хаягдал түр хадгалах талбайг	Хог хаягдлын цэг	Удаа	Өмнөх жил байгуулсан				
	нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө							
	бүхий цементэн суурьтай болгон							
	тохижуулах							

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж	Энгийн хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2025 он	БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал Энгийн хог хаягдлыг
	хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах					ангилах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Төслийн талбай		Үйл ажиллагааны зардал	2025-2029 он	ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага;
	Хаягдал бохир усыг “Ирвэс Интертрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж бие засах газар луу зайлуулах	Ариун цэврийн байгууламж	Удаа		2025-2029 он	БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын
	Хатуу хог хаягдлыг зориулалтын	Төслийн талбайд	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2025 он	төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар;
	битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар					БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал;
	судлалын хяналтын байгууллагын					МЫ8 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
	тогтоосон цэгт зайлуулж байх					
Аюултай хог	Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг	Аюултай хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2025 он	
хаягдал болон	уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах				2025-2029 он	
шатах тослох						
материалаар хөрс, газрын						
доорх ус						

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

бохирдож болзошгүй	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг	Аюултай хог хаягдал	Удаа			
	тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан, хаягдал тос боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан зайлуулах					
Нийт зардал мян. төг				2,000.0		

Хатуу хог хаягдал: Алтны шороон ордыг ашиглах үед үүсэх үйлдвэрийн хог хаягдлыг уурхайн нөхөн дүүргэлтэд ашиглах бөгөөд ахуйн хог хаягдлыг хадгалах, зайлуулах менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа. Алтны шороон ордын ашиглалтын үед өдөрт 19кг, сард 0,5тн, жилд 3,2тн, ашиглалтын хугацаанд 5.5тн ахуйн хатуу хог хаягдал гарна. Үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай зориулалтын саванд цуглуулж, Бөмбөгөр сумын захиргаатай байгуулсан гэрээний үндсэн дээр зайлуулж булшилна.

Шингэн хог хаягдал: Алт угаах үйл ажиллагаанаас гарсан шингэн хаягдлыг тунгаах нуурт тунгааж дахин ашиглах бөгөөд уурхайн ашиглалтын дараа хатаах, зайлуулах аргаар устгана. Харин ажилчдын ахуйн шингэн хаягдлыг уурхайн орчимд байгуулсан түр жорлонд (тусгайлан бэлтгэсэн, хөрс усанд ахуйн бохир алдагдахааргүй доторлосон, агааржуулагч, нян устгагч, үнэр дарагчаар тоногдсон) хадгалах, тогтмол хугацаанд соруулж хаях, эсвэл ашиглалтын дараа булшлах арга хэмжээ авна. Ашиглалтын явцад 19 ажилтан албан хаагч байнга уурхай дээр байна гэж үзвэл өдөрт 0.3 тонн, сард 9тн, ашиглалтын хугацаанд 79.8 тн ахуйн шингэн хог хаягдал гарна. Бохир усны нүхийг зориулалтын дагуу хийж гүйцэлтгүйгээс ус хөрсөнд нэвчих, улмаар газрын доорх усны чанарт нөлөө үзүүлэх аюултай.

5.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2025 он		
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101 болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	Гэрээний үнийн дүнгээр		БО-ны мэргэжилтэн	Байгаль орчныг
				хамгаалах тухай хууль
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр		БО-ны мэргэжилтэн	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох		Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ -нд хүргэж өгөх.	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	12 сард	БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		БО-ны мэргэжилтэн , үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

5.10. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Төслийн үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс, ургамал, амьтанд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд жилд 395.0 мянган төгрөг зарцуулахаар төсөвлөв.

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний ажлын төсвийн тооцоо

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар				100.0	
Хүхрийн исэл 802 Азотын давхар исэл ^02 Нүүрстөрөгчийн дутуу исэл C0 Тоос РМ 2.5 Тоос РМ 10 Дуу чимээ, доргио	Ил уурхайн салхины чиглэлийн дээр, доор - тус бүр 1 цэг Засварын газар - 1 цэг	Жилд 2 удаа	1 дээжний үнэ 50.0	100.0	Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82
Гадаргын болон газрын доорх ус				190.0	
Ундны усны ерөнхий үзүүлэлт болон бактериологи тодорхойлох	Худгийн уснаас	Улиралд 1 удаа	1дээжний үнэ 90.0	90.0	М№ 6148-2010, “Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, МК8 4586:1998, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
вэршүүлсэн саарал ус	Шингээх талбай	Улиралд 1 удаа	1дээжний үнэ 100.0	100.0	МК8 4943:2015 Хүрээлэн байгаа орчин,
Өлзий голын урсгалын хурд, гүн, өргөнийг хэмжиж байх ус судлалын түр харуул байгуулах	Өлзий голоос	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардалд оруулах		Усны чанар, Хаягдал ус, М№ 180 5667-10-2001 дээжлэлт хийх
Хөрс, газрын гадарга				65.0	
Агрохимийн үзүүлэлтүүд (ялзмаг, рН, ЕС2.5 <18/т, P2O5, K2O, CaCO3, \H<, ^02, ^Oз), Механик бүрэлдэхүүн (тоос, элс, шавар)	Машины зогсоол, Хог хаягдлын цэг, ШТМ-ын агуулах, Тосгон, Шимт хөрсний овоолго	Жилд 5 цэгт (1 удаа)	1 дээжний үнэ 20,000	20.0	М№ 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, МК8 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, М№ 3310:1991 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга, М№ 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1, 2-р хэсэг МК8 180 11269-1:2002 Хөрсний чанар. Хөрсний ургамал бохирдуулагч бодисын нөлөөллийг тодорхойлох
Хөрсний хүнд металл (Сг, СМ, РЬ, №, Со гэх мэт)		Хавар, намрын улиралд 5 цэгт (давтамжтай)	1 дээжний үнэ 25,000	25.0	

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөрсний цацраг (Кали, Уран, Тори.)		Жилд 5 цэгт (1 удаа)	1 дээжний үнэ 20,000	20.0	
Ургамал				-	
Ургамлын нягтшил, бүлгэмдэл, зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж байгаа эсэх, бэлчээрийн ургамлын гарц	Уурхайн талбайн эргэн тойрон,сайжруулсан шороон зам	Жилд 2 удаа (хавар, намар)	Компаний байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах (дотоод үйл ажиллагааны зардлаар)	Гео ботаникийн бичиглэлийн батлагдсан аргазүйн дагуу	
	Тарьж ургуулсан мод бут	Сар бүр		Дотоод зохион байгуулалтаар	
Нийт зардал			355.0		

Орчны хяналт шинжилгээний: Төслийн үйл ажиллагааны явцад төлөвлөгдөөгүй судалгаа, хяналт-шинжилгээний ажлууд гарч ирэхийг үгүйсгэх аргагүй юм. Төслийн байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж өгсөн ба жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

Хүснэгт 22. БОМТ-ний нийт зардлын тооцоо

Төлөвлөгөө		Зардал мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Орчны хүчин зүйлс /агаар, ус, хөрс, ургамал/. Байгалийн гамшиг, аваар осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх.	7,645.0
Биологийн олон янз байдлыг “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө		10,000.0
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ		-
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Сум, багийн биет бус соёлын өвийг хадгалан, хамгаалах, хөгжүүлэх	-
	Авран хамгаалах арга хэмжээ	-
ОХШХ-ийг хэрэгжүүлэх зардал		355.0
Хог, хаягдлын менежмент		2,000.0
БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		-
БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах		-
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал		20,000.0